



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улиастай сум  
2025 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)  
Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888

Цахим хаяг: [Munkhnasanb@audit.gov.mn](mailto:Munkhnasanb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan.audit.gov.mn

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Г.АМГАЛАН-Д

2024.02.22 № 236

Тайлбар

№

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 40.070,8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 29.700,0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 163.753,9 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө нэмэгдсэн, холбогдох байгууллагын шийдвэрээр 54.740,3 төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, 35.600,0 мянган төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагад шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагааны мөнгөн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулсан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

8125 492

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	128,873,586.00	143,582,735.00
33	АВЛАГА	500,000.00	500,000.00
335	Бусад авлага	500,000.00	500,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	500,000.00	500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	128,373,586.00	143,082,735.00
354	Хангамжийн материал	128,373,586.00	143,082,735.00
35410	Бичиг хэргийн материал	777,500.00	297,500.00
35420	Аж ахуйн материал	3,842,900.00	2,517,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00
35450	Барилгын засварын материал	4,980,000.00	3,080,000.00
35470	Бусад хангамжийн материал	116,773,186.00	135,188,235.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,121,042,400.78	3,065,977,831.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,121,042,400.78	3,065,977,831.30
392	Биет хөрөнгө	2,608,673,567.43	2,554,961,497.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,384,319,523.00	2,384,319,523.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(264,679,619.30)	(402,327,396.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	299,404,800.00	325,947,431.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(133,312,766.53)	(177,448,869.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,142,759.00	239,303,909.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(76,264,885.77)	(101,510,030.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,516,392.00	34,840,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(41,363,887.59)	(11,572,316.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	445,124,239.00	507,281,239.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(224,212,986.38)	(243,871,990.96)
393	Биет бус хөрөнгө	512,368,833.35	511,016,333.39
39301	Програм хангамж	6,550,000.00	6,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,454,166.65)	(2,806,666.61)
39303	Бусад биет бус хөрөнгө	507,273,000.00	507,273,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,249,915,986.78	3,209,560,566.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	226,433.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	226,433.00
413	Өглөг	-	226,433.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	226,433.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,007,877,986.78	2,967,296,133.30
51	Засгийн газрын хувь оролцоо	3,007,877,986.78	2,967,296,133.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	493,005,760.00	493,005,760.00
51101	Өмч: - төрийн	493,005,760.00	493,005,760.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,421,487,544.65	2,380,905,691.17
51210	Өмнөх үеийн үр дүн	2,421,487,544.65	2,421,487,544.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	(40,581,853.48)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	93,384,682.13	93,384,682.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,007,877,986.78	2,967,522,566.30

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,019,743,445.30	2,069,447,886.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,019,743,445.30	2,069,447,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,019,743,445.30	1,896,909,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,019,743,445.30	1,377,809,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	519,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	172,538,786.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	172,538,786.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,244,728,965.23	2,285,284,679.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,244,728,965.23	2,285,284,679.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,241,412,365.44	2,183,832,914.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,218,759.00	689,973,464.00
210101	Үндсэн цалин	312,211,666.00	412,595,914.00
210102	Нэмэгдэл	123,711,393.00	247,116,250.00
210104	Урамшуулал	21,295,700.00	30,261,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,649,800.00	88,650,300.00
210201	Тэтгэврийн даатгал	39,337,139.98	60,282,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,578,154.77	7,092,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,662,523.76	4,132,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	915,631.01	2,959,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,156,350.48	14,184,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,711,551.61	52,669,570.41
210301	Гэрэл, цахилгаан	6,785,903.61	5,295,590.41
210302	Түлш, халаалт	42,925,648.00	46,669,980.00
210303	Цэвэр, бохир ус	-	704,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,178,847.90	93,017,106.10
210401	Бичиг хэрэг	7,892,100.00	7,116,700.00
210402	Тээвэр, шатахуун	38,265,615.80	60,449,584.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,021,132.10	5,282,821.00
210408	Бараа материал акталсны зардал	-	20,168,001.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,424,500.00	6,924,400.00

210604	Урсгал засвар	12,424,500.00	6,924,400.00
2107	Томилолт, зочны зардал	11,107,800.00	14,713,800.00
210702	Дотоод албан томилолт	11,107,800.00	14,713,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,688,977.00	170,450,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,406,174.00	162,130,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	149,325.00	406,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,903.00	204,029.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	203,400.00
210807	Газрын төлбөр	6,906,575.00	7,432,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	474,432,129.93	1,067,433,458.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,889,010.00	827,904,798.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	303,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	181,393,119.93	239,225,259.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,316,599.79	101,451,765.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	64,006,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,748,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	39,258,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,316,599.79	37,444,865.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,316,599.79	37,444,865.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(224,985,519.93)	(215,836,793.95)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	22,249,999.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	22,249,999.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(22,249,999.85)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(224,985,519.93)	(238,086,793.80)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,019,743,445.30	2,069,447,886.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,019,743,445.30	2,069,447,886.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,019,743,445.30	1,896,909,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,019,743,445.30	1,377,809,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	519,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	172,538,786.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	172,538,786.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,008,343,445.30	2,029,377,086.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,008,343,445.30	2,029,377,086.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,026,845.51	1,927,925,320.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,218,759.00	689,747,031.00
210101	Үндсэн цалин	302,061,213.00	412,369,481.00
210102	Нэмэгдэл	136,302,783.00	247,116,250.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	18,854,763.00	30,261,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,649,800.00	88,650,300.00
210201	Тэтгэврийн даатгал	39,201,900.00	60,282,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,612,000.00	7,092,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,689,600.00	4,132,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	922,400.00	2,959,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,223,900.00	14,184,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,491,551.61	52,669,570.41
210301	Гэрэл, цахилгаан	6,565,903.61	5,295,590.41
210302	Түлш, халаалт	42,925,648.00	46,669,980.00
210303	Цэвэр, бохир ус	-	704,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,124,868.60	72,644,105.10
210401	Бичиг хэрэг	7,661,700.00	6,911,700.00
210402	Тээвэр, шатахуун	30,442,036.50	60,449,584.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,021,132.10	5,282,821.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,846,500.00	9,454,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,422,000.00	2,530,100.00
210604	Урсгал засвар	12,424,500.00	6,924,400.00
2107	Томилолт, зочны зардал	11,107,800.00	14,713,800.00
210702	Дотоод албан томилолт	11,107,800.00	14,713,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,688,977.00	170,450,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,406,174.00	162,130,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	149,325.00	406,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,903.00	204,029.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	203,400.00
210807	Газрын төлбөр	6,906,575.00	7,432,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,898,589.30	829,595,198.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	244,748,589.30	829,291,798.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,316,599.79	101,451,765.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	64,006,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	24,748,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	39,258,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,316,599.79	37,444,865.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,316,599.79	37,444,865.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,400,000.00	40,070,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,400,000.00	40,070,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,400,000.00	40,070,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,400,000.00	40,070,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,400,000.00	40,070,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,400,000.00)	(40,070,800.00)

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,581,853.48)	-	(40,581,853.48)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(40,581,853.48)	-	(40,581,853.48)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	0.00	1324093434.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	1324093434.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	1260086534.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	0.00	689747031.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00	0.00	412369481.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00	0.00	247116250.00
210104	Урамшуулал	0.00	0.00	0.00	30261300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	0.00	88650300.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	0.00	60282100.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	0.00	7092000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	0.00	4132200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	0.00	2959900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	0.00	14184100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	0.00	52669570.41
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	0.00	5295590.41

210302	Түлш, халаалт	0.00	0.00	0.00	46669980.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	0.00	704000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	0.00	50235920.10
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	0.00	6911700.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	0.00	38041399.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	-	5,282,821.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	-	9,454,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-	-	2,530,100.00
210604	Урсгал засвар	-	-	-	6,924,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	14,413,800.00
210702	Дотоод албан томилолт	-	-	-	14,413,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	-	169,316,815.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	160,996,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	-	406,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	-	204,029.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-	-	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-	-	203,400.00
210807	Газрын төлбөр	-	-	-	7,432,286.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	185,598,597.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	185,295,197.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	-	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	64,006,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	64,006,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-	-	24,748,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	-	39,258,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	1,377,809,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	1,377,809,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	1,377,809,100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	27.00	33.00
620001	Удирдах ажилтан	-	-	10.00	10.00

620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	6.00	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	667,838,786.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	667,838,786.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	667,838,786.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	22,408,185.00
210402	Тээвэр, шатахуун	-	22,408,185.00
2107	Томилолт, зочны зардал	-	300,000.00
210702	Дотоод албан томилолт	-	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,134,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,134,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	643,996,601.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	643,996,601.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	172,538,786.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	172,538,786.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	172,538,786.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилтууд:

Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах чиг үүргийн хүрээнд Иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг хууль тогтоомжын хүрээнд эрх тэгш хүнд сурталгүй, ил тод, шуурхай хүргэж сум орон нутгийнхаа хөгжил дэвшилд манлайлагч, мэдлэг чадварт суурилсан төрийн захиргааны байгууллага байх гэсэн зорилт тавин ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Төсвийн тухай хууль
2. НББ-ийн тухай хууль
3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төрийн хэмнэлтийн тухай хууль
6. Эрүүл мэндийн тухай хууль
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахиун тухай хууль
8. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Нягтлан бодох бүртгэлийн ажлын байрны тодорхойлолтод ур чадварын түвшин, мэдлэг мэргэжлийн шаардлагыг бүрэн тусгасан, Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчийн нөлөөлөх оролцоо нь төсвийн хуваарийг баталж өгдөг бөгөөд сум, аймгийн төрийн сан төсвийн зарцуулалтад хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байна. Мөн төсвийн гүйцэтгэл болон хүрэлцээ, шаардлага, өр авлагын талаар дүн шинжилгээ хийж хянаж чиглүүлэх ажлыг хангалттай хийж байна, нягтлан бодогч, нярав гэсэн 2 бүртгэлийн ажилтантай, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг бүрэн хариуцаж хийдэг, төсвийг хэлэлцүүлдэг, Бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх мэдлийн хуваарилалт, холбогдох үүрэг хариуцлагын биелэлт, аливаа зөвшөөрөл олгох ба тайлагнах тогтолцоо нь удирдлага, санхүү төрийн сан, нягтлан бодогч, нярав гэсэн хуваарилалтын дагуу явагддаг, Бүртгэлийн ажилтан авахдаа Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6.3 "аймаг, нийслэлийн төсөвт харьяалагдах байгууллагын төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нь өөрийн төсвийн нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төрийн сангийн хэлтсийн даргатай зөвшилцөнө" гэсэн заалтын хүрээнд томилсон байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сумын засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,064.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Энэ нь акталж устгасан болон хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	128,373.5	143,082.7	14,709.2
Үндсэн хөрөнгө	3,121,042,400.78	3,065,977,831.30	-55,064,569.48
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,249,915,986.78</b>	<b>3,209,560,566.30</b>	<b>-40,355,420.48</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,249,915,986.78	3,209,560,566.30	-40,355,420.48
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,249,915,986.78</b>	<b>3,209,560,566.30</b>	<b>-40,355,420.48</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 128,373.5 мянган төгрөг байгаагаас, төсвийн хөрөнгөөр 195,967.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 181,258.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, эцсийн үлдэгдэл 143,082.7 мянган төгрөг болсон нь өмнөх оноос 14,709.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 40,070.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 29,700.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, 90,340.3 мянган төгрөгийн хөрөнгө шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 3,065,977.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 68,090.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 691.638,7 мянган төгрөг, нийт зарлагыг 2,069,447.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр 172,538.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлж зарцуулсан байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Үйл ажиллагааны орлого, зарлагын дүн</b>					
	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,324,093.4	1,324,093.4	0	100%
	<b>НИЙТ</b>	<b>1,324,093.4</b>	<b>1,324,093.4</b>	<b>0</b>	<b>100%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр Дээд шатны төсвийн захирагчаас 172,538.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 519,100.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж сургуульд автомашин, ус цэвэршүүлэх төхөөрөмж, зам засвар болон бусад төсөл арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/				
№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Сумын 2 сургуульд хүн тээврийн 2 автомашин нийлүүлэх	Автомашин нийлүүлэх	90,000,000	90,000,000
2	Очиртхайрхан ОНӨҮГ-т ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	49,500,000	49,500,000
3	Зам засварын ажил /далан засварлах азда/	/Далан засварлах ажил Азда/	31,440,191	31,440,191
<b>ДҮН</b>			<b>170,940,191</b>	<b>170,940,191</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021

оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг зарим ажил дээр баримталсан байгаа боловч Далан засварлах ажил дээр АЗЗА ОНӨААТҮГ-тай шууд гэрээ байгуулж санхүүжилтийг 2 хувааж олгосон зөрчил байна. Энэ нь Засгийн газрын 02 дугаар тогтоол зөрчсөн байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 3/27 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 2,069,447,8 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 41,388.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 31,041,6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 38 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд алдаа зөрчил илрээгүй байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараахи зөвлөмжүүдийг өгч бүрэн хэрэгжсэн байна.

- Зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох.
- Төлбөрийн актын заасан хугцаанд төлөх.

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тосонцэнгэл сумын засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд эхний хагас жилийн байдлаар завсрын аудит хийгээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,259,4	1	1,259,4	100
Албан шаардлага	2	6,000,0	2	6,000,0	100
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>7,259,4</b>	<b>3</b>	<b>7,259,4</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үр дүнгийн урмашуулал илүү олгосон байдал, яамнаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байдал, томилолтоор явсан ажилчдад хоолны мөнгө давхардуулан олгосон, таван жилийн тэтгэмжийг жил дараалан тасралтгүй ажилласан ажилчдад олгох, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг урьдчилж олгохгүй байх зэрэгт анхаарах.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 125,886.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 121,440.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 2,796.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,650.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт өгсөн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс ихгүй байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажилласан эмч нарт 1,650,000 төгрөгийн хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

Халаалтын зардлыг олгохдоо үнийн тариф тогтоолгоогүй аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж 2,796.6 мянган төгрөгийн зөрүүг илүү олгосонд албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал..

#### Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, нэг ажлын санхүүжилтийг 2 хувааж тендер зарлахгүйгээр олгосон зэрэг 31,440.1 мянган төгрөгийн зардал гаргасан.

#### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх; Засгийн газрын 02 дугаар тогтоол хэрэгжүүлж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

#### Илрүүлэлт:

Техникийн тодорхойлолтод заасан зааврын дагуу автомашин нийлүүлээгүй, өгсөн тоо хэмжээнд заасны дагуу хүлээн аваагүй, Бензин машин захиалсан байхад дизель машин хүлээн авсан байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>17,482.7</b>					<b>2</b>	<b>17,482.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн ажиллагаа	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Албан томилолтоор ажилласан эмч нарт 1,650,000 төгрөгийн хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.	1	1,650,0	1	1,650,0								
Халаалтын зардлыг олгохдоо үнийн тариф тогтоолгоогүй аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж 2,796.6 мянган төгрөгийн зөрүүг илүү олгосонд албан шаардлага хүргүүлсэн.	1	2,796,7			1	2,796,7						
Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, нэг ажлын санхүүжилтийг 2 хувааж тендер зарлахгүйгээр олгосон зэрэг 31,440.1 мянган төгрөгийн зардал гаргасан.	1	31,440,1					1	31,440,1				
Техникийн тодорхойлолтод заасан зааврын дагуу автомашин нийлүүлээгүй, өгсөн тоо хэмжээнд заасны дагуу хүлээн аваагүй, Бензин машин захиалсан байхад дизель машин хүлээн авсан байна.	1	90,000,000					1	90,000,000				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>125,886,8</b>	<b>1</b>	<b>1,650,0</b>	<b>1</b>	<b>2,796,7</b>	<b>2</b>	<b>121,440,1</b>				

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-23

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР

Огноо: 2025-02-23

Б.МӨНХНАСАН